



2022

ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хүчтэй. Хамтдаа.

Тайлангийн агуулга

#	Агуулга	
1	Удирдлагын тайлан	Удирдлагын тайлан
2	Бүтэц, зохион байгуулалт	Компанийн бүтэц ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн Удирдлагын бүтэц Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
3	Гадаад, дотоод орчин	
4	Үйл ажиллагааны тайлан	Харилцагчдын өсөлт Ард Апп Арилжаа Хөрөнгө оруулалтын багц Урамшууллаар олгосон АрдКойн
5	Санхүүгийн гүйцэтгэл	Гол үзүүлэлт Орлогын Дэлгэрэнгүй тайлан Санхүүгийн Байдлын тайлан Үнэлгээ
6	Компанийн засаглал	Компанийн Засаглалын үнэлгээ Засаглалын бүтэц

Удирдлагын захидал

Хүчтэй. Хамтдаа.

Удирдлагын захидал



Эрхэм хүндэт Ардын хувьцаа эзэмшигч танаа!

Та бүхэн надад итгэн удирдахыг даалгасан компанийн гүйцэтгэлийн талаарх шинэ мэдээг тантай хуваалцахдаа баяртай байна. Компанийн үйл ажиллагааны орчин бидний хувьд бүх талаараа хамгийн сорилттой үе байлаа. Тухайлбал “КОВИД-19” цар тахлын нөлөөгөөр үүссэн нийлүүлэлтийн сүлжээний тасалдал болон Орос-Украин хоорондох дайны улмаас үүдэлтэй инфляцийн түвшин Монгол Улсад 16 хувьд хүрэв. Доллартай харьцах төгрөгийн ханш 10 гаруй хувиар буурч 3,150 төгрөг болсон бөгөөд Төв банк бодлогын хүүгээ 6 хувиас 10 хувь болгож өсгөлөө. Хил хаасан нь Монголын эдийн засгийн гол түнш болох Хятад Улс руу чиглэсэн түүхий эдийн экспортод нөлөөлж, улмаар бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдсан. Энэхүү тасалдал нь “Крипто өвөл”-тэй зэрэгцэн биткойны ханш сүүлийн нэг жилийн доод түвшинд хүрч, салбарын томоохон тоглогчдын хөрвөх чадвар муудсан нь манай үйл ажиллагаанд хүндээр нөлөөлсөн. Ардын компаниудын хувьцааны ханш өнгөрсөн жилтэй харьцуулахад 50-75 хувиар буурч, АрдКойны ханш 475 төгрөгөөс 95 хүртэл хувиар буурлаа.

Энэ уналт зөвхөн бидэнд тулгарсан уу? Энэ нөхцөл байдал тасралтгүй үргэлжлэх үү? Хэрэв та эргэн тойрноо ажиглавал Tesla-ийн хувьцаа 60 хувиар буурч, Coinbase-ийн хувьцаа IPO хийснээсээ хойш 85 хувиар, Биткойны ханш 77 хувиар буурсан болохыг харж болно. Мөн Монголын Хөрөнгийн Биржийн ТОП 20 индекс 25 хувиар буурчээ.

Бид бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахын сацуу Ард Санхүүгийн Нэгдлийн хүний нөөцийн орон тоог багасгалаа. Үүний зэрэгцээ менежментийн багийг дахин зохион байгуулахаар шийдэж, тодорхой функцуудыг шинээр бий болгох зарим нэг удирдлагын багийн гишүүдийн ажил үүргийг нэмэгдүүллээ. Мөн тодорхой чиглэлийн компаниудыг нэгдсэн кластерт оруулж удирдлага зохион байгуулалтын хувьд үр ашигтайгаар зохион байгуулав.

Нэгдлийн бүтцийг өөрчлөн зохион байгуулах асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхийн сацуу зарим нэг компаниудын үйл ажиллагааг нэгтгэж энэ жил UBX дээр хэд хэдэн компанийн IPO-г гаргахаар ажиллаж байна.

МХБ-ийн хамгийн идэвхтэй арилжигдсан үнэт цаасны жагсаалтыг Ардтай холбоотой хувьцаанууд тэргүүлсэн хэвээр байна. AARD хувьцаа 2 жилийн өмнөхөөс 1.2 дахин өсөлтийг үзүүлж өнөөдөр 3,300 болсон байгаа нь гүйцэтгэл сайн байгааг илэрхийлж байна. АрдКойн 18 сарын өмнө нэг төгрөгийн ханштай байсан бөгөөд тухайн үед 2021 оны эцэс гэхэд 20 төгрөгт хүрэх амбицтай төлөвлөгөөг санал болгож байснаа санаж байна.

Бид өнгөрсөн онд хөрөнгө оруулалт хийсэн компаниудаа хүчирхэгжүүлсээр байна. ТэнГэр телевиз үйл ажиллагаагаа эхлүүлж, богино хугацаанд олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж эхэллээ — ТэнГэрЛиг Медиа Нэгдэл өргөжин тэлсээр байна. DAX-ийг рибрэндинг хийж iDAX болгон өөрчилсөн бөгөөд 6-р сард Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлтээ өргөн барьсан. UBX нь анхны IPO төсөл дээрээ ажиллаж байна. Анхны нээлттэй сан болох Хөрөнгө Оруулагч Үндэстэн СЗХ-д нэгж эрхийн танилцуулгаа бүртгүүлж, нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах зөвшөөрлөө авсан.

Хүчтэй. Хамтдаа.

Удирдлагын захидал

Бид санхүүгийн үүргээ биелүүлэхийн тулд шаргуу ажилласаар байна - Бондын төлбөр, хөрөнгө оруулалтын хойшлуулсан төлбөр, татварын өр болон бусад төлбөрийг мэргэжлийн түвшинд удирдан ажиллаж байна.

- Турк Улсын Истанбул хотноо 6-р сард болсон Бичил Санхүүгийн Төвийн бага хуралд оролцох багийг илгээсэн бөгөөд энэ жил шинэ санхүүжилт, хөрөнгө оруулагчдын хувьд тодорхой үр дүнг хүлээж байна.
- Хоёр жил завсарласны дараа зохион байгуулагдсан "Монголын эдийн засгийн форум 2022"-ыг бид ивээн тэтгэн, тэтгэврийн шинэчлэлийн төлөө тууштай зүтгэсээр байна.
- Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчид UBХ руу шилжих санал өгсөн.
- NFT нээлттэй зах зээлийг ard.art дээр эхлүүлсэн.
- Бидний санаачилсан DeFi төсөл болох ArdMoney үргэлжилсээр байна. DEX 6-р сард эхэлсэн.
- Улаанбаатар хотноо уламжлал болгон зохион байгуулагддаг “Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулга уулзалтын үеэр хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгууллаа.
- Хөрөнгө оруулагч үндэстэн баримтат кино тавдугаар сард нээлтээ хийв.
- Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит компаниуд 2021 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ олголоо.
- Алдарт Хүннү рок урсгалын хамтлаг болох THE HU хамтлаг метаверс дахь анхны тоглолтоо зохион байгуулахад бид дэмжлэг үзүүлэх гэрээнд гарын үсэг зурсан ба Ардын экосистем нь энэхүү шинэхэн төслийн платформ нь болох юм.
- Нийлүүлэлтийн сүлжээний финтек төсөл болох СКОПА болон түүний Гүүд платформыг амжилттай эхлүүлэв.
- Ард Даатгал оны эхний зургаан сард 12 тэрбум төгрөгийн хураамжийн орлогоороо дээд амжилт тогтоожээ. Ард Кредитийн зээлийн багц 42 тэрбум төгрөг болов. Ард Актив тогтвортой өсөлтөө хадгалсаар байна.

Ирэх 6 сарын хувьд бид дараах сорилттой нүүр тулна - Хөрвөх чадвар чанга хэвээр байх бөгөөд бэлэн мөнгө “хаан” байх болно.

Бид DAX платформыг UBХ-д хүлээлгэн өгөхийн сацуу краудфандинг платформ болон/эсвэл секюрити токен арилжааны платформ болгон өөрчлөн зохион байгуулахаар ажиллах болно. Ард Аппын 5 дахь хувилбарыг энэ онд багтан гаргахаар төлөвлөж байна. Бид ирэх улиралд Хөрөнгө Оруулагч Үндэстэн нээлттэй сангийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

Хүндэтгэсэн,

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх Захирал Хутагт овогт Чулууны Ганхуяг

Хүчтэй. Хамтдаа.

Компанийн бүтэц

КОМПАНИЙН БҮТЭЦ

ТУЗ-ийн гишүүд - 9
Ажилчид - 17



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ


Ердийн гишүүд



Чулууны **Ганхуяг**
Гүйцэтгэх Захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл



Бруно Рашле
Дэд Дарга,
Шродер Адвек



Авирын **Сүхдорж**
Үүсгэн байгуулагч,
ГрэйпСити Монгол ХХК



Одончимэдийн **Одбаяр**
Гүйцэтгэх Захирал,
Mon-International

ТУЗ-ийн Дарга



Пүрэвжаргалын **Батбаяр**
ТУЗ-ийн Дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл

Хараат бус гишүүд



Мөнх-Очирын **Сэргэлэн**
Ерөнхийлөгч,
IET



Михаил Зелдович
Хяналтын зөвлөлийн дарга,
Кокуун капитал



Чулууны **Мөнхбат**
Ерөнхийлөгч,
Саусгоби сэндс



Арно Вентура
Удирдах Партнер,
Гожо Компани

Хүчтэй. Хамтдаа.

УДИРДЛАГЫН БАГ



Чулууны **Ганхуяг**
Гүйцэтгэх захирал



Батбилэгийн **Золбоо**
Санхүү Эрхэлсэн
Захирал



Жаргалангийн **Алтангүний**
Төр Засаг, Олон Нийтийн Харилцаа
Эрхэлсэн Захирал



Баярсайханы **Оюутцэцэн**
Эрсдэл Эрхэлсэн
Захирал



Отгонбаяр **Амарболд**
Борлуулалт Эрхэлсэн
Захирал



Сүхбаатарын **Анар-Эрдэнэ**
Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн
Захирал



Мөнхбатын **Мөнх-Эрдэнэ**
Дотоод Аудитор



Эрдэнэбатын **Баярмагнай**
Технологи Эрхэлсэн
Захирал

Хүчтэй. Хамтдаа.

ОХИН КОМПАНИЙН УДИРДЛАГА



Галбадрах **Цогбадрах**
Гүйцэтгэх захирал,
Ард Даатгал



Гэрэлт **Тэлмэн**
Гүйцэтгэх захирал,
Ард Кредит



Цолмон **Бархас**
Гүйцэтгэх захирал,
Ард Секюритиз



Булган **Гантулга**
Гүйцэтгэх захирал,
Ардын Тэтгэврийн Данс



Ганхуяг **Билгүүн**
Гүйцэтгэх захирал,
Ард Актив



Гүррагчаа **Сүхбаатар**
Гүйцэтгэх захирал,
Ард Лизинг



Баяраа **Ариунаа**
Гүйцэтгэх захирал,
АрдШоп



Чулуунбаатар **Хандаа**
Гүйцэтгэх захирал,
Ард Менежмент



Эрдэнэбат **Баярмагнай**
Гүйцэтгэх захирал,
ТэнГэр Системс



Отгонбаяр **Амарболд**
Гүйцэтгэх захирал,
Ард Лайф

Хүчтэй. Хамтдаа.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

#	Хувьцаа эзэмшигч	2021 Q2	Эзэмшил	2021 Q4	Эзэмшил	2022 Q2	Эзэмшил	YTD	YTD %
1	И Ай Ти	4,586,973	16.0%	4,212,438	14.7%	3,745,605	13.1%	(466,833)	(11.1%)
2	АрдЭкс	891,569	3.1%	1,057,697	3.7%	1,076,380	3.8%	18,683	1.8%
3	Ардын Тэтгэврийн Данс	2,139,994	7.5%	2,204,781	7.7%	2,166,340	7.6%	(38,441)	(1.7%)
4	Бруно Рашле	2,104,592	7.4%	2,104,592	7.4%	2,106,396	7.4%	1,804	0.1%
5	А.Сүхдорж	568,266	2.0%	1,226,377	4.3%	1,941,591	6.8%	715,214	58.3%
6	Ард Холдингс Интернешнл	1,599,616	5.6%	1,470,419	5.1%	1,454,202	5.1%	(16,217)	(1.1%)
7	Г.Уянга	1,346,936	4.7%	1,381,936	4.8%	1,385,113	4.8%	3,177	0.2%
8	Ч.Ганхуяг	1,349,513	4.7%	1,368,264	4.8%	1,384,948	4.8%	16,684	1.2%
9	Ард Лизинг		0.0%	803,072	2.8%	836,453	2.9%	33,381	4.2%
10	Ард Секюритиз	1,076,316	3.8%	962,620	3.4%	529,578	1.9%	(433,042)	(45.0%)
11	Н.Мөнхнасан	603,401	2.1%	603,401	2.1%	486,401	1.7%	(117,000)	(19.4%)
12	С.Гэрэлтуяа	455,935	1.6%	455,935	1.6%	455,935	1.6%	0	
13	Ронок Лимитед	479,111	1.7%	479,111	1.7%	443,816	1.6%	(35,295)	(7.4%)
14	Ард Даатгал	411,455	1.4%	411,455	1.4%	406,850	1.4%	(4,605)	(1.1%)
15	С.Оргил	283,800	1.0%	283,800	1.0%	390,680	1.4%	106,880	37.7%
Топ 15 хувьцаа эзэмшигчид		17,897,477	62.5%	19,025,898	66.5%	18,810,288	65.7%	(215,610)	(1.1%)
Бусад хувьцаа эзэмшигчид		10,716,786	37.5%	9,588,365	33.5%	9,803,975	34.3%	215,610	2.2%
Эргэлтэд буй хувьцаа		28,614,263	100.0%	28,614,263	100.0%	28,614,263	100.0%		
Хувьцаа эзэмшигчид		17,520		18,793		18,480		(313)	(1.7%)
ARDT эзэмшигчид		7,673		6,591		6,596		5	0.1%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

DAХ дээр **ARDT** эзэмшигч 6,592

НИЙТ
54,457




Хүчтэй. Хамтдаа.

Гадаад, дотоод орчин


Хүчтэй. Хамтдаа.

ГАДААД ОРЧИН

Хүү, инфляц



Мөнгөний нилүүлэлт (тэрбум төгрөг)



2022 оны 5-р сард улсын хэмжээнд инфляц оны эхнээс 7.9 хувь, өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар өссөн нь бодит орлого болон өрхийн хэрэглээнд сөргөөр нөлөөлөв. Төв банкны хяналтаас гадуурх нийлүүлэлтийн гаралтай инфляц учир дэлхийн эдийн засгийн нөлөөллийг тусгаж 2022 онд дунджаар **14.5 хувь** байх төлөвтэй байна.



Төв банк өсөн нэмэгдэж буй инфляцийг саармагжуулах, валютын ханш гадаад сөрөг нөлөөллийг шингээх, гадаад болон улсын өрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бодлогын хүүг 6 хувиас 10 хувь болгов.

ГАДААД ХУДАЛДАА

2022 худалдаа сараар (сая доллар)

Худалдаа
(сая доллар)

ГБАН ба USDMNT




Монгол Улс он гарсаар дэлхийн 145 оронтой худалдаа хийж, худалдааны нийт бараа эргэлт 9.3 тэрбум долларт хүрч, үүний 5.3 тэрбум долларыг экспорт, 3.9 тэрбум долларыг импорт бүрдүүлсэн байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны мөн үеийнхээс 1.9 тэрбум доллар буюу 26.0 хувь, үүний дотор экспорт 1.2 тэрбум доллар буюу 29.9 хувь, импорт 687.0 сая доллар буюу 21.1 хувиар өсч, гадаад худалдааны ашиг 1.4 тэрбум доллартай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 534.8 сая доллараар өссөн.

Орос, Украины дайн нь гадаад орчны эрсдэлийг нэмэгдүүлж, гадаад валютын эрэлт нэмэгдэж, олон улсын нөөц улам бүр багассан. Тиймээс үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш суларсан.


УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ӨР

FitchRatings В 'Тогтвортой'


2022 сараар (тэрбум доллар)



5 сар YTD (тэрбум доллар)



Гадаад өр (сая доллар)




Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ эхний хагас жилд 7.3 их наяд төгрөг болж, 919.2 тэрбум төгрөг буюу 14.3 хувиар, зарлага, цэвэр зээлийн нийт хэмжээ 8.2 тэрбум төгрөг болж, 844 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 8.8 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарав.

Улсын өрийн ДНБ-д эзлэх харьцаа сүүлийн улиралд буурч, 2020 оны 4-р улиралд 73.6%-иар оргилдоо хүрч байсан бол 2022 оны эхний улиралд 62% болж буурсан. Засгийн газрын нийт өрийн 90 гаруй хувь нь гадаад зээл ба үндсэн төлбөрийн гуравны нэг нь ирэх онд төлөгдөнө. Тиймээс Засгийн газар төсвийн нэгдмэл байдлыг хадгалахыг эрмэлзэх төлөвтэй байна. Тавдугаар сард Fitch Ratings Монгол Улсын гадаад валютаар үнэт цаас гаргагчийн урт хугацааны дефолт зэрэглэлийг В гэж баталсан.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа


Үнэт цаас	Зах зээл	2021Н1	2022Н1	YoY
Хувьцаа	Хоёрдогч	119.55	113.69	-5%
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Анхдагч	4.00	55.00	1,275%
	Хоёрдогч	0.14	2.99	2,018%
Компанийн бонд	Анхдагч	355.74	79.72	-78%
	Хоёрдогч	161.73	22.20	-86%
Хөрөнгө оруулалтын сан	Хоёрдогч	5.49	2.34	-57%
Total		646.65	275.93	-57%



Эхний хагас жилийн байдлаар МХБ-ийн зах зээлийн нийт үнэлгээ 4.9 их наяд төгрөгт хүрч, 19.1 хувиар бууран, өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хөрөнгийн биржид бүртгэлтэй Ардын компаниуд нийт зах зээлийн үнэлгээний 4.5 хувийг эзэлж байна. ТОП 20 индекс 32,796 - 44,119, дунджаар 37,759 байна. Улирлын эцэст тус индекс 32,796 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар буюу 719.33 нэгжээр буурчээ.

Эхний хагас жилд нийт 275.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, өмнөх оны мөн үеэс 57.3 хувиар буюу 370.7 тэрбум төгрөгөөр буурсан. Өдрийн дундаж арилжааны дүн 2.3 тэрбум төгрөг болж, МХБ-д бүртгэлтэй Ардын долоон компани бүгд хамгийн идэвхтэй арилжигдсан үнэт цаасны жагсаалтад багтлаа. Нийт арилжааны хэмжээ 23.1 тэрбум төгрөг буюу тухайн хугацаанд хувьцаа болон хөрөнгө оруулалтын сангийн нийт арилжааны 20 хувийг эзэлж байна.

КРИПТОВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ




2021 он гарснаас хойш криптовалютууд 2 их наяд долларын үнэ цэнээ алдлаа. Биткойны үнэ эхний хагаст 60%-иар унасан нь инфляци, хүүгийн өсөлт зэрэгтэй адил хувьцааны ханшид сөргөөр нөлөөлөв. Криптовалютын салбарт гарсан өвөрмөц үйл явдлуудаас үүдэн хөрөнгө оруулагчдын итгэл буурсан бөгөөд Terra blockchain болон UST stablecoin уналтад орж, хөрөнгө оруулагчид 40 тэрбум долларын алдагдал хүлээсэн. Дижитал хөрөнгөд зориулагдсан ЗАС хедж сан татан буугдан, хэрэглэгчдэд криптогоо хадгалуулбал 18%-иас дээш өгөөжийг санал болгодог банктай төстэй компани болох Celsius дампуурлаа зарлалаа.

Виртуал хөрөнгийн үнэ цэнийн алдагдлаас улбаалан дотоодын зах зээл ч идэвхгүй болсон. 2021 оны өсөлтийн үед Монголд криптовалютын зах зээл нэг их наяд төгрөгийг татан төвлөрүүлсэн гэсэн тооцоо бий. Виртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчийн тухай хууль 2022 оны 2-р сарын 24-с хэрэгжиж эхэлсэн бөгөөд СЗХ-с дагалдах журмуудыг батлан гаргасан.

Үйл ажиллагааны тайлан

Хүчтэй. Хамтдаа.

ХАРИЛЦАГЧДЫН ӨСӨЛТ



Хүчтэй. Хамтдаа.

2022 оны II улирлын байдлаар

АРД АПП

2021 он

2022 У2

625k

22k

шинэ харилцагч бүртгэв

62.6

40.2

тэрбум төгрөг
онлайн зээл олгов

29.6

9.7

тэрбум төгрөг
үнэт цаасны арилжаа гүйцэтгэв

744.3


216

тэрбум төгрөг
шилжүүлэг хийв

4.7

2.5

тэрбум төгрөг
хуримтлал үүсгэв










Сайжруулалт, хөгжүүлэлт

- ✖ Харилцагчийн бүртгэл шинэчлэгдэж, ДАН системтэй холбогдов
- ✖ Харилцагчийн хамгаалалтыг сайжруулав
- ✖ Шинэ бүтээгдэхүүн - итгэлцэл, барьцаатай зээл, дуудлага худалдаа
- ✖ КАСПО төслийг хэрэгжүүлж, UBХ болон МХБ-ийн арилжаа
- ✖ QR, QPay холболт
- ✖ ArdKids апп

Ard App V5

- 🦒 UX / UI сайжруулалт
- 🦒 Speech-to-Text
- 🦒 Хиймэл оюун ухаан

АРИЛЖАА



— Ханш
■ Арилжаа

	Нээлт (2022/1/1)	YTD low	YTD high	Хаалт (2022/6/30)	YTD өөрчлөлт	33Y (тэрбум)	Эргэц (%)	Арилжааны дүн (тэрбум)	% of МХБ хувьцаа & сан
AARD	9,080	3,215	9,785	3,323	(63%)	95	9.6%	19.2	16.7%
AIC	1,346	719	1,349	735	(45%)	18	8.7%	2.1	1.8%
ADB	213	91	220	93	(56%)	26	2.3%	0.9	0.8%
XOC	198	109	199	115	(42%)	6	6.1%	0.5	0.4%
BUN	162,000	52,600	164,900	52,600	(68%)	6	2.9%	0.4	0.3%
TNGR	19,000	11,000	23,100	13,200	(31%)	79	0.4%	0.5	0.4%
MNP	1,231	788	1,350	804	(35%)	80	0.1%	0.1	0.1%
						310		23.7	20.5%

Хөрөнгө оруулалтын багц

Банк

ББСБ



40.6%

15.3%
Үл хөдлөх

ХЗХ



9.91%

85%
Лизинг

Даатгал

Даатгал



45.4%


9.1%

Тэтгэврийн сан



95%

Амьдралын даатгал



97%

Хөрөнгө оруулалт

ҮЦК



90%

ХОМК



90%

Хөрөнгө оруулалт



100%

ХОС



0.2%
21.9%

ХОС




Дэд бүтэц

Харилцаа, холбоо



23.6%
7.0%

Лоялти



100%

Ард Академи



100%

● Ард Санхүүгийн Нэгдэл

● Холбоотой талууд

▲ Нээлттэй компани

* 2022 оны 6-р сарын 30-ны байдлаар

Хөрөнгө оруулалтын багц

Арилжаа

Үнэт цаасны бирж



43.7%*

Виртуал бирж



70%

Виртуал бирж



100%

Платформ

Төлбөрийн систем



45%

DeFi initiative



25%

Нийлүүлэлтийн сүлжээ



Цахим худалдаа



61.2%

Технологи

Програм хангамж хөгжүүлэлт



45%

NFT



49%

Метаверс хөгжүүлэлт



10%

Мэдээлэл технологи



100%

Хөгжүүлэгч



51%

Медиа нэгдэл

Медиа нэгдэл



41.83%

TB



20%*

Контент




20%

Контент



66%

TB



100%*

Медиа



100%*

Студио



20%*

- Ард Санхүүгийн Нэгдэл
- Холбоотой талууд
- Нээлттэй компани

* 2022 оны 6-р сарын 30-ны байдлаар

Санхүүгийн гүйцэтгэл


Аудитын хорооны дүгнэлт

2022 оны хагас жилийн жилийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайланд дотоод аудитын хянаж баталгаажуулан, дотоод аудитын хороонд танилцуулсан бөгөөд компанийн санхүүгийн тайлангийн тоон үлдэгдлүүд Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитоор илэрхийлэгдсэн гэж дүгнэлээ.


2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон жилийн эцсийн санхүүгийн тайланд завсар үеийн, жилийн эцсийн хөндлөнгийн аудитаар Олон улсад бүртгэлтэй Грант Торнтон аудитыг сонгон ажиллуулахыг дэмжсэн.

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ


Үнэлгээ
(сая төгрөг)



Нийт хөрөнгө
(сая төгрөг)




Цэвэр ашиг
(сая төгрөг)




Хөрөнгө оруулалтын багц
(сая төгрөг)



Эздийн өмч
(сая төгрөг)



Дэлгэрэнгүй ашиг
(сая төгрөг)



Хүчтэй. Хамтдаа.

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Key Financials	Q4 2020	Q2 2021	Q4 2021	Q2 2022	YTD	YoY
Share Price (MV)	1,758	9,385	9,785	3,323	(66%)	(65%)
# of shares	27,175,629	28,614,263	28,614,263	28,614,263	0%	0%
MV of AARD (MNT million)	47,775	268,545	279,991	95,085	(66%)	(65%)
Net assets (MNT million)	55,832	382,621	258,049	216,088	(16%)	(44%)
BV per share	2,054	13,372	9,018	7,552	(16%)	(44%)
Earnings (TTM, MNT million)	(4,034)	(181)	(214)	445	308%	346%
EPS	(148)	(6)	(8)	16	308%	348%
PE ratio	(12)	(1,484)	(1,308)	214	116%	114%
PB ratio	0.90	0.70	1.10	0.40	(64%)	(43%)
ROE (TTM)	(0.08)	(0.00)	(0.00)	0.00	433%	322%
ROA (TTM)	(0.05)	(0.00)	(0.00)	0.00	420%	300%
LT Investments to Assets	95%	95%	88%	90%	2%	(5%)
LT Investments to Equity	137%	112%	113%	110%	(2%)	(2%)
Debt to Equity	31%	5%	8%	7%	(13%)	48%
Current ratio	0.15	1.02	0.83	1.06	28%	4%

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

сая төгрөгөөр	Q4 2020	Q2 2021	Q4 2021	Q2 2022 ⁽¹⁾	YoY
Хөрөнгө оруулалтын орлого	304	8,429	17,708	3,503	(58%)
Ногдол ашгийн орлого	1,312	965	1,004	965	0%
Хүүний орлого	31	938	1,316	449	(52%)
Түрээсийн орлого	770	240	753	1,000	317%
Бусад үйл ажиллагааны орлого	0	33	32	498	1,409%
Менежментийн орлого	688	839	2,030	1,455	73%
Нийт орлого	3,106	11,445	22,843	4,367	(62%)
Санхүүгийн зардал	2,889	1,497	3,346	1,728	15%
Боловсон хүчний зардал	1,552	927	1,681	798	(14%)
Мэргэжлийн үйлчилгээний зардал	0	0	10,944	0	
Бусад үйл ажиллагааны зардал	2,676	3,388	6,523	3,214	(5%)
Нийт зардал	7,117	5,811	22,495	5,739	(1%)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(170)	(1)		(45)	(4,400%)
Бусад ашиг (алдагдал)	145	(323)	(590)	(208)	36%
Татварын өмнөх ашиг	(4,037)	5,309	(242)	(1,625)	(131%)
Татварын зардал	(2)	679	(27)	(890)	(231%)
Цэвэр ашиг (алдагдал)	(4,035)	4,630	(214)	(735)	(116%)
Бодит үнэ цэнийг өөрчлөлт	4,235	317,817	198,869	(51,500)	(116%)
Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	200	322,448	198,655	(52,235)	(116%)

(1) Хуримтлагдсан ашиг тайлант үеийн ашиг болон хөрөнгө оруулалт борлуулснаас олсон олзоор нэмэгдэж, ногдол ашиг олгосон дүнгээр буурсан. Хөрөнгө оруулалтын ААН-ийн бүртгэлийн дагуу СТОУС 10-т заасны дагуу хөрөөнгө оруулалт борлуулснаас олсон олзыг тайлант үеийн ашгаас тусад нь бүртгэсэн.

Хүчтэй. Хамтдаа.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

сая төгрөгөөр	Q4 2020	Q2 2021	Q4 2021	Q2 2022 ⁽¹⁾	YTD	YoY
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	101	35	331	409	24%	1,069%
Авлага	1,687	19,151	23,184	19,779	(15%)	3%
Урьдчилж төлсөн зардал	1,244	4,017	3,708	4,570	23%	14%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	19	19	20	20	0%	5%
Үндсэн хөрөнгө	906	380	2,995	2,442	(18%)	543%
Биет бус хөрөнгө	113	207	350	266	(24%)	29%
Виртуал хөрөнгө	8,828	173,401	58,810	53,821	(8%)	(69%)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	67,481	254,648	242,081	189,439	(22%)	(26%)
Нийт хөрөнгө	80,380	451,858	331,479	270,746	(18%)	(40%)
Дансны өглөг	2,810	5,995	8,049	12,734	58%	112%
Татварын өглөг	170	467	1,250	1,425	100%	205%
Хүүний өглөг	597	582	403	226	100%	(61%)
УОО	29	29	11,017	9,379		32,241%
Богино хугацаат өр төлбөр	1,297	709	8,964	1,760	100%	148%
Гаргасан бонд	14,305	9,920	5,268	2,886	(45%)	(71%)
Урт хугацаат өр төлбөр	1,935	7,298	14,290	10,322	(28%)	41%
Хойшлогдсон татварын өр	3,405	44,238	24,189	18,443	(24%)	(58%)
Нийт өр төлбөр	24,548	69,237	73,431	57,175	(22%)	(17%)
Энгийн хувьцаа	27,176	28,614	28,614	28,614	0%	0%
Нэмж төлөгдсөн капитал	0	2,928	2,928	2,928	0%	0%
Хуримтлагдсан ашиг	1,359	5,964	12,145	19,168	58%	221%
Дахин үнэлгээний нөөц	27,284	345,101	214,347	162,847	(24%)	(53%)
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14	14	0%	0%
Нийт эздийн өмч	55,832	382,621	258,049	213,571	(17%)	(44%)

ҮНЭЛГЭЭ

(сая төгрөг)	арга	Q4 2020	%	Q2 2021	%	Q4 2021	%	Q2 2022	%	YTD	YoY
Стратегийн хөрөнгө оруулалт		67,450		344,081		397,700		169,999		(57.25%)	(50.59%)
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	17,689	23.68%	28,181	23.6%	31,727	23.6%	18,895	23.6%	(40.45%)	(32.95%)
Ард Даатгал (MSE: AIC)	MV	13,108	65.54%	16,523	45.5%	14,970	45.4%	8,339	45.4%	(44.30%)	(49.53%)
Ард Кредит (MSE: ADB)	MV	14,080	61.25%	28,408	40.6%	25,009	40.6%	10,611	40.6%	(57.57%)	(62.65%)
Ард Секюритиз	BV	2,305	100.00%	19,126	100%	15,756	100%	6,279	90%	(60.15%)	(67.17%)
Ард Менежмент	BV	1,265	100.00%	12,271	100%	6,708	100%	2,181	90%	(67.49%)	(82.23%)
Ард Актив	BV	99	9.50%	415	9%	741	9%	757	10%	2.16%	82.41%
Ард Лайф	BV	11,426	100.00%	46,048	95%	33,217	95%	2,308	95%	(93.05%)	(94.99%)
Ард Лизинг	BV			10,168	100%	5,256	100%	4,676	100%	(11.04%)	(54.01%)
ТэнГэр Системс	BV	1,154	100.00%	9,302	100%	9,950	100%	3,684	100%	(62.97%)	(60.40%)
Ард Холдингс Интернешнл	BV	6,324	100.00%	13,193	100%	15,002	100%	5,659	100%	(62.28%)	(57.11%)
Ард Пропертиз	BV			48,472	100%	34,965	100%	2,198	100%	(93.71%)	(95.47%)
Ард Бит	BV			111,974		84,023		3,683		(95.62%)	(96.71%)
DAX*	DCF				60%	45,000	60%	45,000	60%	0.00%	
Даац хөрөнгө оруулалт (54% of UBX)	Cost					4,096		4,096		0.00%	
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	MV					57,780	48%	38,135	48%	(34.00%)	
ГрэйпСити Монгол	Cost					9,000		9,000		0.00%	
Мост Финтек	Cost					4,500		4,500		0.00%	
Тактикийн хөрөнгө оруулалт		50		5,707		15,729		1,941		(87.66%)	(65.99%)
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	MV	3	0.05%		0%	19	0%	11	0%	(42.11%)	
Булган Ундрага (MSE: BUN)	MV	28	32.89%	5,667	30%	5,319	28%	1,893	28%	(64.41%)	(66.60%)
Бусад өмч болон бонд		19		40		10,391		37		(99.64%)	(7.50%)
Бусад		-8,263		117,023		40,137		(13,214)		(132.92%)	(111.29%)
Үндсэн болон биет бус хөрөнгө		9,407		118,820		62,155		11,433		(81.61%)	(90.38%)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		101		35		331		406		22.66%	1,060.00%
Бусад цэвэр хөрөнгө		(17,771)		(1,832)		(22,349)		(25,052)		(12.09%)	(1,267.47%)
Нийт үнэлгээ		59,237		466,811		453,566		158,727		(65.00%)	(66.00%)
Эргэлтэд байгаа хувьцааны тоо		27,175,629		28,614,263		28,614,263		28,614,263			
Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)		2,180		16,314		15,851		5,547		(65.01%)	(66.00%)

Компанийн Засаглал


Компанийн Засаглалын үнэлгээ

AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК – Өөрийн үнэлгээ	Оноо	Хувь
№	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН 9 ЗАРЧИМ	72	100%
НЭГ.	ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ - 12		
	ТУЗ нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна	11	15%
ХОЁР.	ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ - 10		
	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	7	10%
ГУРАВ.	ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ – 6		
	ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	6	8%
ДӨРӨВ.	АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО - 6		
	ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана	6	8%
ТАВ.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА - 8		
	ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина	6	8%
ЗУРГАА.	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ - 6		
	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	4	6%
ДОЛОО.	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ - 8		
	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	8	11%
НАЙМ.	КОМПАНИЙН СОЁЛ - 6		
	ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	6	8%
ЕС.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ - 10		
	Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	9	13%
НЭГДСЭН ДҮН		63	87.5%

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



Дээд түвшиний
Компанийн
засаглал



Хамгаалалтын
гурван давхарга

Гуравдах давхарга

Дотоод Аудитор

Дотоод Аудит нь бие даасан эрсдэлийн үнэлгээ болон компанийн засаглал, баталгаажуулалт, зөвлөмж гарган ажиллах

Хоёрдох давхарга

Хяналтын хэлтэсүүд

Санхүүгийн удирдлага, Мэдээллийн аюулгүй байдал, Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг цаг алдалгүй ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх

Эхний давхарга

Бүх хэлтэс, ажилчид

Өдөр тутмын үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх

Хүчтэй. Хамтдаа.